



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 04 сарын 23 өдөр

Дугаар 1173

Шивээговь сум

Төв талбайн усалгаа, арчилгаа, зүлэгжүүлэх  
ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3.л, 29.2, 31 дүгээр зүйлийн 31.1.7, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын төв талбай, цэцэрлэгт хүрээлэнг цэцэгжүүлэх, зүлэгжүүлэлт, усалгаа, арчилгаа хийх ажлыг 2020 оны 05 дугаар сарын 08-ны өдөр суманд үйл ажиллагаа явуулж буй албан байгууллага, аж ахуйн нэгжүүд зохион байгуулсугай.

2. Төв талбайг зүлэгжүүлэх, цэцэгжүүлэх, усалгаа, арчилгаа хийх албан байгууллага, аж ахуйн нэгжийн хуваарийг 1 дүгээр хавсралтаар, цэцэрлэгт хүрээлэнд мод тарих хуваарийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Өөрийн байгууллагын хуваарьт газруудад зүлэгжүүлэлт, усалгаа арчилгааны ажилд ажилтан, албан хаагчдаа бүрэн хамруулах, цаашид 7 хоног бүр чанартай хийж гүйцэтгэхийг албан байгууллага, аж ахуйн нэгжийн дарга, захирал, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

4. Сумын төв талбай болон цэцэрлэгт хүрээлэнд мод тарих, усалгаа арчилгаа, зүлэгжүүлэх ажлыг тогтоосон хугацаанд чанартай зохион байгуулж ажиллахыг 1, 2 дугаар багийн Засаг дарга нарт, хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны мэргэжилтэн, Байгаль хамгаалагч нарт тус тус даалгасугай.

5. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж, үр дүнг тухай бүр танилцуулахыг Засаг даргын орлогч /Ж.Батмөнх/-д үүрэг болгосугай.


ЗАСАГ ДАРГА




С. ЯГААНЦЭЦЭГ

4212 02 3


Сумын Засаг даргын 2020 оны 04-р сарын 23 ний өдрийн 1/23 дугаар захирамжийн 1-р хавсралт



Төв талбайн усалгаа, арчилгаа, зүлэгжүүлэлт, цэцэгжүүлэлт хийх талбайн хуваарилалт



Сумын Засаг даргын 2020 оны 04-р сарын 23 ний өдрийн 1173 дугаар захирамжийн 2-р хавсралт



Цэцэрлэгт хүрээлэнгийн усалгаа арчилгаа мод бут тарих талбайн зураглал

3-р Сургууль	ААНБ-ууд	ЭМТ	ИШОНӨҮГ-р	ЗДТГ-р
Иргэд Шивээговь сумын Бөхийн холбоо	3-р Цэцэрлэг	Цагдаагийн хэсэг, Шивээговь сумын шагайн холбоо, Мал эмнэлгийн нэгж	Соёлын төв, БЗӨБЦТС ТӨК Шивээговь салбар, Бүжинхэн бүл цэцэрлэг,	Шивээ-сервис Сүмбэр алт ломбард,

Жич: Модны нүх усалгаа, арчилгааг, Байгууллага иргэд өөрсдөө хийнэ. Мөн албан байгууллагууд ААН-үүд, ажилчид, гишүүдийн тоогоор мод бут тарьж зурвас байгуулна. Мод бутны захиалгыг байгаль хамгаалагч авна. Утас:86133909